

БАТЛАВ.
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН

ДАРГА

.....

БАТЛАВ.
.....
.....
.....

ХАЛАЛ СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭ, СТАНДАРТЫН ТЭМДЭГЛЭГЭЭ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

20.... оны ...сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэг талаас Стандарт, хэмжил зүйн газар, Улсын бүртгэлийн 9070002082, Регистрийн 9096035 дугаартай, түүнийг төлөөлж Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг (цаашид “Гэрчилгээ эзэмшүүлэгч” гэх), нөгөө талаас Улсын бүртгэлийн Регистрийн дугаартай, “ ” ХХК, түүнийг төлөөлж Захирал /албан тушаал, нэр/ (цаашид “Гэрчилгээ эзэмшигч” гэх) нар Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны дугаар сарын -ны өдрийн тоот тушаалаар Халал баталгаажуулалтын стандартыг хэрэгжүүлсэн тухай гэрчилгээг олгохтой холбогдуулан, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13.3, 25.3.6, 27.1.1, 27.2.2, 31.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн дараах зүйлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

1.2. Халал стандартыг нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилготой энэхүү гэрээгээр Гэрчилгээ эзэмшүүлэгч нь Халал баталгаажуулалтын тогтолцооны стандарт OIC/SMICC; GSO тэмдэглэгээтэй стандартыг хэрэгжүүлсэн тухай гэрчилгээ, уг менежментийн тогтолцооны стандартын тэмдэг болох HALAL стандартын тэмдэглэгээ (цаашид “стандартын тэмдэглэгээ” гэх)-г хэрэглэх эрхийг гэрчилгээ эзэмшигчид олгохоор тохиролцов.

1.3. Энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд Стандарт, хэмжил зүйн газрын албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах үүрэгтэй.

Хоёр. Гэрчилгээ эзэмшүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Халал стандартыг хэрэгжүүлсэн тухай гэрчилгээ, уг тогтолцооны тохирлын тэмдэг болох стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрх авсан талаар мэдээлнэ.

2.2. Гэрчилгээ эзэмшигчийн Халал стандартыг хэрэгжилтийн тогтвортой байдал, үйл ажиллагаанд энэхүү гэрээний дагуу хяналт тавьж, аливаа асуудлыг эрх хэмжээнийхээ дагуу шийдвэрлэнэ.

2.3. Гэрчилгээ эзэмшигчээс энэ гэрээний 3.7-д заасны дагуу ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох шийдвэрийг гаргана.

2.4. Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийн нууцыг хадгална.

2.5. Гэрчилгээ эзэмшигчийн менежментийн тогтолцооны хэрэгжилтэд магадлах аудитыг гэрээний 1 дүгээр хавсралтын дагуу явуулж, шаардлагатай чиглэл өгнө.

2.6. Менежментийн тогтолцооны стандартын өөрчлөлтийн тухай мэдээллийг гэрчилгээ эзэмшигчэд тухай бүр хүргүүлнэ.

2.7. Халал тэмдгийг бүтээгдэхүүн тус бүр дээр болон бүтээгдэхүүний хайрцаганд байршуулсан байдалд хяналт хийж, тэмдгийг зөв байршуулаагүй бол залруулуулах талаар арга хэмжээг авна.

2.8. Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах талаар үйлчлүүлэгч нэг бүртэй хийсэн хуулийн хүчин төгөлдөр гэрээтэй байна. Түүнчлэн, баталгаажуулалтын байгууллага олон салбартай үйлчлүүлэгч олон байрлалтай тохиолдолд баталгаажуулалт олгож буй баталгаажуулалтын байгууллага болон баталгаажуулалтын хамрах хүрээн дэх бүх байрлалыг хамарч буй үйлчлүүлэгчийн хооронд хуулийн хүчин төгөлдөр гэрээтэй байна.

Гурав. Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн баримт бичиг дээр болон сурталчилгааны байдлаар халал стандартын тэмдэглэгээг хэрэглэх эрхтэй.

3.2. Халал стандартын шаардлагын нийцэлд магадлах аудитыг гэрээний 1 дүгээр хавсралтад зааснаар гэрчилгээ эзэмшүүлэгчээр хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд хавсралтад өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж, гэрчилгээ эзэмшүүлэгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ. Шинэчилсэн хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

3.3. Гэрчилгээнд заагаагүй хамрах хүрээнд гэрээний нөхцлийг хэрэглэж болохгүй.

3.4. Гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг Гэрчилгээ эзэмшүүлэгчээс түр буюу бүрмөсөн зогсоосон тохиолдолд түүнийг хэрэглэх эрхгүй.

3.5. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тогтвортой хадгалж Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн холбогдох заалтууд, бүтээгдэхүүн, үйлчилгээний стандарт, гэрээний шаардлага болон Халал стандартын шаардлагыг хангаж ажиллана.

3.6. Менежментийн тогтолцоонд нөлөөлөхүйц /жишээлбэл, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, үйл явц зэрэг/ өөрчлөлт орсон тухай бүр гэрчилгээ эзэмшүүлэгчид нэн даруй мэдээлнэ.

3.7. Менежментийн тогтолцоонд нөлөөлөхүйц /жишээлбэл, удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, үйл явц зэрэг/ өөрчлөлт орсон тухай бүр гэрчилгээ эзэмшүүлэгчид нэн даруй мэдээлнэ.

3.8. Менежментийн тогтолцооны баталгаажуулалт, аудитын үйлчилгээний төлбөрийг түүний үр дүнгээс үл хамааран гэрээний 2 дугаар хавсралтад заасны дагуу хугацаанд нь бүрэн төлнө.

3.9. Ажлын үр дүнгийн үзүүлэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гэрчилгээ эзэмшүүлэгчид ирүүлнэ.

3.10. Менежментийн тогтолцоо, халал стандартад өөрчлөлт орсон тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь энэ тухай гэрчилгээ эзэмшүүлэгчид мэдэгдэж, шинэчлэгдсэн стандартын дагуу дахин аудит хийлгэх асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

3.11 Халал тэмдгийг бүтээгдэхүүн тус бүр дээр болон бүтээгдэхүүний хайрцаганд байршуулна. Хэрвээ тэмдгийг буруу хэрэглэсэн байвал залруулна.

Дөрөв. Гэрээний хугацаа

4.1. Энэхүү гэрээ нь гэрээний 5 дугаар зүйлд заасан нөхцөлөөр түр зогссон, хүчингүй болгосноос бусад тохиолдолд оны дугаар сарын -ны өдөр хүртэл хугацаанд хүчинтэй байна.

4.2. Гэрчилгээ эзэмшигч нь гэрээний хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө гэрээний хугацаа сунгуулах хүсэлтээ гэрчилгээ эзэмшүүлэгч байгууллагад ирүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

4.3. Талууд гэрээний 4.1-т заасан хугацаа дуусахаас өмнө түүнийг сунгуулаагүй бол энэ гэрээ хүчингүйд тооцогдоно. Гэрээ хүчингүй болсноор гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрх мөн адил дуусгавар болно.

Тав. Гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг түр зогсоох, хүчингүй болгох, энэ гэрээг цуцлах

5.1. Дараах тохиолдолд гэрчилгээ эзэмшүүлэгч нь гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг түр хугацаагаар зогсоож, зөрчил, доголдлыг нь арилгуулах арга хэмжээ авахуулна. Үүнд:

5.1.1. Гэрчилгээ эзэмшигчийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаа нь Халал стандартын шаардлага хангахгүй тохиолдолд;

5.1.2. Гэрчилгээ эзэмшигч нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

5.1.3. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар хэрэглэгч, худалдан авагчаас үндэслэл бүхий гомдол удаа дараа гаргасан;

5.1.4. Гэрчилгээ эзэмшигч нь гэрээнд заасан үйлчилгээний үнэ, зардлыг тохиролцсон хугацаанаас хойш 30 хоногийн дотор төлөөгүй;

5.1.5. Гэрчилгээ эзэмшигч гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэхтэй холбогдсон дүрэм, журмыг зөрчсөн;

5.2. Гэрчилгээ эзэмшүүлэгчээс гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг түр зогсоосон үед өөрийн баримт бичиг буюу бүтээгдэхүүний сав баглаа боодол, шошго дээр, эсвэл бусад байдлаар менежментийн тогтолцооны стандартын тэмдэглэгээ хийх буюу уг стандартыг хэрэгжүүлсэн талаар зарлал, сурталчилгаа хийхийг хориглоно.

5.3. Гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг түр зогсоосон хугацаанд гэрчилгээ эзэмшигч 5.1.1-т дурдсан холбогдох зөрчил, доголдлоо арилгаж, үүнийгээ гэрчилгээ эзэмшүүлэгчид албан бичгээр мэдэгдэж, магадлуулан нотолсон нөхцөлд гэрчилгээ эзэмшүүлэгч нь уг эрхийг сэргээж болно.

5.4. Энэ гэрээний 5.1.1-т заасан нөхцлөөр эрхийг түр зогсоосон үед гэрчилгээ эзэмшигч нь зөрчил, доголдлыг арилгаагүй бол гэрчилгээ эзэмшүүлэгчээс гэрээг цуцалж, эрхийг хүчингүй болгоно.

5.5. Гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг хүчингүй болгох үндсэн нөхцөл:

5.5.1. Илэрсэн зөрчил нь бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт ноцтой нөлөөлөхөөр бол;

5.5.2. Гэрчилгээ эзэмшигч нь гэрээний нөхцлийг зөрчсөн;

5.5.3. Гэрчилгээний хүчинтэй хугацааг түр зогсоосон үед гэрчилгээ эзэмшигч нь зөрчил, дутагдлаа арилгах талаар тодорхой арга хэмжээ аваагүй;

5.5.4. Гэрчилгээ эзэмшигч аж ахуйн нэгж татан буугдсан буюу тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ажил үйлчилгээ эрхлэхээ зогсоосон;

5.5.5. Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй;

5.5.6. Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх эрхийг бусдад дур мэдэн шилжүүлсэн.

Зургаа. Санал, гомдол

6.1. Гэрээ байгуулагч талууд энэ гэрээний биелэлтийн талаар болон гэрээнд хамаарах асуудлаар гарсан аливаа зөрчилтэй зүйлийн талаар харилцан тохиролцоогүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид зааснаар эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэхээр гомдол гаргах эрхтэй.

Гэрээ байгуулсан талуудыг төлөөлж:

Гэрчилгээ эзэмшүүлэгчийг
төлөөлж:
СХЗГ-ын Бүтээгдэхүүн,
тогтолцооны баталгаажуулалтын
газрын дарга
.....

СХЗГ-ын Санхүүгийн хэлтсийн
дарга
.....

Захиргаа, удирдлагын газрын Эрх
зүйн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн
.....

Хаяг: Энхтайвны өргөн чөлөө-46
Данс: Төв төрийн сан банкны
100900009012

Гэрчилгээ эзэмшигчийг төлөөлж:

Чанарын менежер

Хуулийн зөвлөх

.....

Байгууллагын хаяг:

Холбоо барих ажилтны нэр, утасны
дугаар:

..... дугаартай гэрээний 1-р хавсралт

“.....” ХХК - ийн
Халал стандартын хэрэгжүүлэлтэд онд
СХЗГ-аас магадлах аудитын үйлчилгээ үзүүлэх график

- 1.Халал стандарт: OIC SMICC: GSO
- 2.Бүртгэлийн дугаар:
- 3.Байгууллагын төлөөлөгч:
- 4.Хамрах хүрээ:
- 5.Ажиллагсадын тоо (хамрах хүрээний дотор):

Аудитын дугаар	Аудитад хамрагдах байгууллага, салбар нэгж	Хэзээ явуулах, он сар	Аудитын ажлын хэмжээ хүн/өдөр	Үйлчилгээний төлбөрийн журам
2023/01	Хамрах хүрээнд	2023 сард	... хүн/... өдөр	
2024/01	Хамрах хүрээнд	2024 сард	... хүн/... өдөр	

..... дугаартай гэрээний 2-р хавсралт

“.....” ХХК - ийн
Халал стандартын баталгаажуулалт, аудитын үйлчилгээ
үзүүлэх төлбөр, зардал

д/д	Үйлчилгээний нэр, хэмжээ	Төлбөр, төгрөг	Тайлбар
2023 онд			
1	Гэрчилгээ эзэмшүүлж, Халал стандартын тэмдэглэгээ хэрэгжүүлэх үйлчилгээний жилийн төлбөр	
2	Магадлах аудитын төлбөр	
Дүн:			
2024 онд			
1	Гэрчилгээ эзэмшүүлж, Халал стандартын тэмдэглэгээ хэрэгжүүлэх үйлчилгээний жилийн төлбөр	
2	Магадлах аудитын төлбөр	
Дүн:			